

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДААТГАЛЫН ГАЗАР**

**ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН 2010 ОНЫ
1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**

ТАНИЛЦСАН:

ХОРООНЫ ДАРГА
ХОРООНЫ ГИШҮҮН
ХОРООНЫ ГИШҮҮН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Д. БАЯРСАЙХАН
Б. ШАРАВСАМБУУ
Д. ДҮГЭРЖАВ
Х. БУМ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
ДААТГАЛЫН ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА

С. ГАНБОЛД
П. ЦЭРЭНДЭЖИД

БОЛОВСРУУЛСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН ХЯНАН ШАЛГАГЧ
ДААТГАЛЫН ГАЗРЫН ХЯНАН ШАЛГАГЧ

Б. ОЮУНТУЯА
Э. ЭРДЭНЭТУЯА

УЛААНБААТАР ХОТ
2010 ОН

ГАРЧИГ

I.	ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3
II.	ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	4
III.	ДААТГАГЧ БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ОРЛОГО	8
IV.	ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР	9
V.	НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН	12
VI.	ДАВХАР ДААТГАЛ	14
VII.	ДҮГНЭЛТ	14

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН 2010 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2010 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын зах зээл дээр 17 даатгалын компани, 131 даатгалын компанийн салбар, 1874 даатгалын төлөөлөгч, 6 даатгалын зуучлагч компани, 3 даатгалын хохирол үнэлэгч компани, 10 актуарч, нийт 2041 тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагаагаа явуулсан байна (Хүснэгт-1).

Хүснэгт-1

**Даатгалын зах зээл дээрх тусгай
зөвшөөрөл эзэмшигчид, тоогоор**

№		2009 - I	2010 - I
1	Даатгагч	16	17
2	Даатгалын компанийн салбар	120	131
3	Даатгалын төлөөлөгч	1167	1874
4	Даатгалын зуучлагч	4	6
5	Даатгалын хохирол үнэлэгч	-	3
6	Даатгалын актуарч	9	10
	Бүгд	1 316	2 041

Энэ оны 1 дүгээр улиралд “Юу ай си даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг цуцалсан бол “Лоялти солюшн” ХХК-д даатгалын зуучлагчийн, “Вендо” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрлийг тус тус шинээр олгосон байна.

График-1




Дээрх графикаас харахад дотоодын даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд, хувь хүмүүсийн тоо 2007 оноос 2009 оны хооронд жигд өсөлттэй буюу 2,3 дахин өссөн дүнтэй байгаа нь энэхүү зах зээл хурдацтай хөгжиж байгааг илтгэж байна (График-1).

II. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

2010 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын зах зээл дээр урт хугацааны болон ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын нийт хөрөнгө 40,7 тэрбум төгрөг болж өнгөрөгч 2009 оны 1 дүгээр улиралтай харьцуулахад 1,16 дахин өссөн буюу 5,8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгө буурах болсон шалтгаан нь “Нийслэл даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотой юм. Салбарын нийт хөрөнгө 2007 оноос 2009 он хүртэл тогтвортой өсч байсан бол 2010 оны 1 дүгээр улиралд үл ялиг буурсан дүнтэй гарсан байна (График-2).

График-2



2009 оны 1 дүгээр улиралд системийн дүнгээр нийт эргэлтийн хөрөнгө 30.3 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 86,8 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 4.6 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 13,2 хувийг эзэлж байсан бол 2010 оны 1 дүгээр улиралд эргэлтийн хөрөнгө 35.6 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 87,5 хувь, эргэлтийн бус хөрөнгө 5.1 тэрбум төгрөг болж нийт хөрөнгийн

12,5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 0,7 пунктээр өөрчлөгдсөнөөс харахад тайлант хугацаанд хөрөнгийн бүтцэд мэдэгдэм өөрчлөлт гараагүй байна (Хүснэгт-2).

Хүснэгт-2

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө

(сая төг)

Үзүүлэлтүүд	2009 - I		2010 - I		өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Эргэлтийн хөрөнгө	30 289.4	86.8	35 598.7	87.5	5 309.3	117.5
Эргэлтийн бус хөрөнгө	4 614.5	13.2	5 095.5	12.5	481.0	110.4
Нийт хөрөнгө	34 903.9	100.0	40 694.3	100.0	5 790.4	116.6

Даатгагчийн нийт хөрөнгийн дийлэнх хэсгийг бүрдүүлдэг эргэлтийн хөрөнгийн бүтцийг 2010 оны 1 дүгээр улирлын байдлаар харахад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ хамгийн өндөр буюу 66,0 хувь, богино хугацаат хөрөнгө оруулалт 18,5 хувь, нийт авлага 12,3 хувь, үүнээс даатгалын хураамжийн авлага 5,2 хувь, бусад эргэлтийн хөрөнгө 3,2 хувийг тус тус эзэлж байна. Энэхүү бүтцийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад эргэлтийн хөрөнгөнд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эзлэх хувь 5,6 пунктээр буурсан бол богино хугацаат хөрөнгө оруулалтын эргэлтийн хөрөнгөнд эзлэх хувь 6,1 пунктээр өссөн дүнтэй байна (Хүснэгт-3).

Хүснэгт-3

Эргэлтийн хөрөнгийн бүтэц

(сая төг)

Үзүүлэлтүүд	2009 - I		2010 - I		Өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	21 675,9	71,6	23 496,0	66,0	1 820,1	108,4
Богино хугацаат хөрөнгө оруулалт	3 749,3	12,4	6 572,7	18,5	2 823,4	175,3
Нийт авлага Үүнээс: даатгалын хураамжийн авлаг	3 802,0	12,6	4 390,0 1 846,7	12,3 5,2	588,0	115,5
Бусад эргэлтийн хөрөнгө	1 062,2	3,5	1 140,0	3,2	77,8	107,3
Эргэлтийн хөрөнгийн дүн	30 289,4	100,0	35 598,7	100,0	5 309,3	117,5

Эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь хэмжээ 87,5 хувь буюу өндөр байгаагийн гол шалтгаан нь Хорооны 2008 оны 242 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага” журмын дагуу даатгалын компанийн дүрмийн болон нөөц сангийн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хэлбэрээр байршуулах шаардлага түлхүү тавигдаж байгаатай холбоотой байгаа болно.

2010 оны 1 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын компаниудыг хөрөнгийн хэмжээгээр жагсаахад “Монгол даатгал” ХХК 12.4 тэрбум төгрөгийн

хөрөнгө буюу нийт зах зээлийн 30,4 хувийг эзэлж даатгалын салбарыг нийт хөрөнгийн хэмжээгээрээ тэргүүлж байгаа бол “Соёмбо инк даатгал” ХХК 0.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр нийт зах зээлийн 1,5 хувийг эзэлж байна (Хүснэгт-4).

Хүснэгт-4

Даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ


№	Даатгалын компанийн нэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төг)	Эзлэх хувь
1	Монгол даатгал ХХК	12 364.7	30.4
2	Прайм женерал даатгал ХХК	3 795.7	9.3
3	Бодь даатгал ХХК	3 523.6	8.7
4	Миг даатгал ХХК	2 823.0	6.9
5	Практикал даатгал ХХК	2 690.0	6.6
6	Номин даатгал ХХК	2 252.7	5.5
7	Ард даатгал ХХК	2 132.6	5.2
8	Түшиг даатгал ХХК	1 670.0	4.1
9	Улаанбаатар хотын даатгал ХХК	1 253.8	3.1
10	УБ даатгал ХХК	1 220.9	3.0
11	Ган зам даатгал ХХК	1 174.9	2.9
12	Монгол траст холдинг даатгал ХХК	1 165.8	2.9
13	Нэйшнл лайф даатгал ХХК	1 105.1	2.7
14	Гранд ко даатгал ХХК	1 011.8	2.5
15	Мөнх даатгал ХХК	970.6	2.4
16	Жонон даатгал ХХК	923.8	2.3
17	Соёмбо инк даатгал ХХК	615.1	1.5
	Ердийн болон урт хугацааны даатгалын дүн	40 694.1	100.0

2009 оны 1 дүгээр улиралд “Монгол даатгал” ХХК нь даатгалын салбарт нийт хөрөнгийн хэмжээгээрээ даатгалын зах зээлийн 35,3 хувийг эзэлдэг байсан бол 2010 оны 1 дүгээр улиралд 30,4 хувийг эзлэх болж 4,9 пунктээр буурсан нь 2009 оны сүүлийн хагас жилд даатгалын компаниуд шинээр нэмэгдсэн болон даатгагч бусад компаниуд үйл ажиллагаагаа тэлж байгаатай холбоотой байна.

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 3 жилийн 1 дүгээр улирлын байдлаар харьцуулж харахад 2008 оны 1 дүгээр улиралд нөөц сан 63,0 хувийг эзэлж байсан бол 2009 оны 1 дүгээр улиралд 43,0 хувь болж буурсан, 2010 оны 1 дүгээр улиралд 58,5 хувь болон буцаж өссөн дүнтэй гарсан байна. Энэ нь 2009 онд орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн санг Хорооны 2008 оны 241 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагын мэдээллийн

сангийн журам”-ын хавсралтын дагуу балансын нөөцийн сангийн хэсгээс хасч, өр төлбөр хэсэг дэх урьдчилж орсон орлогоор бүртгэж байсныг өөрчилж, 2010 оноос орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг даатгалын нөөц сан руу буцаан шилжүүлсэнтэй холбоотой (График-3).

График-3



Эзэмшигчдийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувь сүүлийн 3 жилийн эхний улирлын байдлаар тогтвортой өсч ирсэн дүнтэй байна.

2010 оны 1 дүгээр улиралд “Гранд ко даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Мөнх даатгал” ХХК, “Соёмбо инк даатгал” ХХК, “Нэйшнл лайф даатгал” ХХК-иуд алдагдалтай ажилласан боловч даатгалын салбарын хэмжээний хуримтлагдсан ашиг 2,4 дахин өссөн дүнтэй байна (Хүснэгт-5).

Хүснэгт-5

	2009 - I		2010 - I		Өсөлт/бууралт	
	тоо (сая төг)	эзлэх хувь	тоо (сая төг)	эзлэх хувь	тоо (сая төг)	эзлэх хувь
Эзэмшигчдийн өмч	10 732.9	91,8	11 850.7	83,6	1 117.8	110,4
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	958.6	8,2	2 325.4	16,4	1 366.8	2,4 дахин
Эзэмшигчдийн өмчийн дүн	11 691.5	100,0	14 176.1	100,0	2 484.6	121,3

III. ДААТГАГЧ БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ОРЛОГО

2010 оны 1 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид нийт 5.1 тэрбум төгрөгийн орлого олсон байна. Энэхүү орлогын 98,6 хувийг ердийн даатгалын компаниуд, 1,0 хувийг урт хугацааны даатгалын компани, 0,4 хувийг даатгалын зуучлагч компаниуд, 0,04 хувийг даатгалын хохирол үнэлэгч компаниудын олсон орлого тус тус бүрдүүлсэн болно.


Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн олсон нийт орлогын 96,0 хувь буюу 4,9 тэрбум төгрөг нь даатгалын нийт хураамжийн орлого, үлдэх хэсэг нь бусад орлого болон даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч компаниудын олсон орлого байна. Энэхүү даатгалын нийт хураамжийн орлого олсон даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээ нь 4.4 их наяд төгрөг болсон байна.

Даатгалын нийт хураамжийн орлогын ерөнхий хандлага нь тасралтгүй өсч байгаа хэдий ч сүүлийн 2008-2009 оны байдлаар жилийн өсөлтийн хурдац буурсан болохыг график-4 харуулж байна.

Даатгалын компаниуд даатгалын нийт хураамжийн орлогын 22,0 хувийг давхар даатгалд, 0,8 хувийг буцаасан даатгалын хураамжид төлж 3.8 тэрбум төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлоготой ажилласан байна.

2010 онд 1 дүгээр улиралд олсон даатгалын нийт хураамжийн орлогын 55,3 хувь буюу 2.8 тэрбум төгрөгийг даатгалын төлөөлөгчөөр, 1,6 хувь буюу 77.2 сая төгрөгийг даатгалын зуучлагчаар дамжуулан олсон байна.

График-4



Даатгалын компаниудыг 2010 оны 1 дүгээр улиралд олсон даатгалын нийт хураамжийн орлогоор жагсаахад нийт хураамжийн орлогын 37,7 хувь буюу 1,9 тэрбум төгрөгийг “Монгол даатгал” ХХК бүрдүүлж тэргүүлсэн бол “Прайм женерал даатгал” ХХК нийт хураамжийн

орлогын 20,1 хувь буюу 1.0 тэрбум төгрөгийг, “Бодь даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 16,8 хувь буюу 0.8 тэрбум төгрөгийг бүрдүүлснээр нийт зах зээлийн 74,6 хувийг эдгээр компаниудын даатгалын хураамжийн орлого эзэлсэн байна (Хүснэгт-6).

Хүснэгт-6

№	Даатгалын компанийн нэр	Даатгалын нийт хураамжийн орлого (сая төг)	Эзлэх хувь
1	Монгол даатгал ХХК	1 889.8	37.7
2	Прайм женерал даатгал ХХК	1 010.0	20.1
3	Бодь даатгал ХХК	841.7	16.8
4	Номин даатгал ХХК	255.5	5.1
5	Миг даатгал ХХК	222.3	4.4
6	Ган зам даатгал ХХК	211.3	4.2
7	Ард даатгал ХХК	182.2	3.6
8	Практикал даатгал ХХК	93.4	1.9
9	Соёмбо инк даатгал ХХК	85.0	1.7
10	Нэйшнл лайф даатгал ХХК	46.5	0.9
11	Мөнх даатгал ХХК	45.7	0.9
12	Түшиг даатгал ХХК	45.5	0.9
13	Улаанбаатар хотын даатгал ХХК	39.0	0.8
14	Гранд ко даатгал ХХК	27.7	0.6
15	УБ даатгал ХХК	16.9	0.3
16	Жонон даатгал ХХК	0	0.0
17	Монгол траст холдинг даатгал ХХК	0	0.0
18	Юу ай си даатгал ХХК	0	0.0
	Дүн	4 963.6	100.0

IV. ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ОЛГОВОР

2010 оны 1 дүгээр улиралд нийт 4.96 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсны 23,8 хувь буюу 1.18 тэрбум төгрөг нь хөрөнгийн даатгалын, 22,0 хувь буюу 1.09 тэрбум төгрөг нь авто тээврийн хэрэгслийн даатгалын, 13,1 хувь буюу 650.5 сая төгрөг нь агаарын хөлгийн даатгалын, 12,8 хувь буюу 633.9 сая төгрөг нь хариуцлагын даатгалын, 10,9 хувь буюу 542.9 сая төгрөг нь гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалын, 6,6 хувь буюу 329.9 сая төгрөг нь авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгалын, 4,4 хувь буюу 217.6 сая төгрөг нь санхүүгийн даатгалын, 6,3 хувь буюу 315.0 сая төгрөг нь ачааны даатгалын, барилга угсралтын даатгалын, газар тариалангийн даатгалын, мал амьтдын даатгалын хураамжаас орсон орлого тус тус бүрдүүлсэн байна (График-5).

График-5



Тайлбар: ачааны даатгал, барилга угсралтын даатгал, газар тариалангийн даатгал, мал амьтдын даатгалыг бусад ангилалд хамруулав.

2010 оны 1 дүгээр улирлын даатгалын хураамжийн орлогын хэмжээг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулахад 1.1 тэрбум төгрөгөөр буюу 28,5 хувиар өссөн дүнтэй гарсан байна (Хүснэгт-7).

Хүснэгт-7

Даатгалын хураамжийн орлого


(сая төг)

№	Даатгалын ангилал	2009-И	2010-И
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал (2009 онд амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал)	381.9	542.9
2	Хөрөнгийн даатгал		1180.4
3	Автотээврийн хэрэгслийн даатгал		1093.4
4	Ачааны даатгал		137.1
5	Газар тариалангийн даатгал		0.3
6	Мал амьтдын даатгал		2.1
7	Агаарын хөлгийн даатгал		650.5
	2009 онд эд хөрөнгийн даатгал бүгд	2 740.7	3063.8
8	Барилга угсралтын даатгал		175.5
9	Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал		329.9

10	Хариуцлагын даатгал		633.9
	<i>2009 онд хариуцлагын даатгал бүгд</i>	<i>485.4</i>	<i>1139.3</i>
11	Санхүүгийн даатгал	253.2	217.6
	Дүн	3 861.2	4 963.6

2010 оны 1 дүгээр улиралд нийт 1.64 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосны 24,8 хувь буюу 407.0 сая төгрөг нь хөрөнгийн даатгалын, 43,8 хувь буюу 719.7 сая төгрөг нь авто тээврийн хэрэгслийн даатгалын, 1,0 хувь буюу 1.7 сая төгрөг нь агаарын хөлгийн даатгалын, 3,3 хувь буюу 55.0 сая төгрөг нь хариуцлагын даатгалын, 9,3 хувь буюу 153.4 сая төгрөг нь гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалын, 12,3 хувь буюу 202.2 сая төгрөг нь авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгалын, 3,4 хувь буюу 55.7 сая төгрөг нь санхүүгийн даатгалын, 2,3 хувь буюу 37.7 сая төгрөг нь бусад даатгалын нөхөн төлбөрт тус тус олгогдсон байна (График-6).

График-6



Тайлбар: ачааны даатгал, барилга угсралтын даатгал, газар тариалангийн даатгал, мал амьтдын даатгал, агаарын хөлгийн даатгалыг бусад даатгалын зэргийг хамруулав.

2010 оны 1 дүгээр улиралд даатгуулагчдад олгосон даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулахад 432.0 сая төгрөгөөр буюу 26,3 хувиар өссөн дүнтэй гарсан байна (Хүснэгт-8).

Хүснэгт-8

Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ

(сая төг)

№	Даатгалын ангилал	2009-I	2010-I
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал (2009 онд амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал)	133.0	153.4

2	Хөрөнгийн даатгал		407.0
3	Автотээврийн хэрэгслийн даатгал		719.7
4	Ачааны даатгал		9.5
5	Газар тариалангийн даатгал		0.0
6	Мал амьтдын даатгал		0.0
7	Агаарын хөлгийн даатгал		1.7
	<i>2009 онд эд хөрөнгийн даатгал бүгд</i>	<i>801.1</i>	<i>1137.9</i>
8	Барилга угсралтын даатгал		37.7
9	Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал		202.2
10	Хариуцлагын даатгал		55.0
	<i>2009 онд хариуцлагын даатгал бүгд</i>	<i>163.5</i>	<i>294.9</i>
11	Санхүүгийн даатгал	<i>112.5</i>	<i>55.7</i>
	Дүн	<i>1 210.1</i>	<i>1 641.9</i>

V. ХОХИРОЛ НӨХӨЛТИЙН ТҮВШИН

2010 оны 1 дүгээр улиралд даатгалын хохирол нөхөлтийн түвшин даатгалын салбарын дүнгээр 33,1 хувь болж 2009 оны мөн үеийнхээс 4,5 пунктээр нэмэгдсэн байна (График-7).

График-7



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын хохирол нөхөлтийн түвшингээр харьцуулахад 2010 оны 1 дүгээр улирлын байдлаар “УБ даатгал” ХХК хамгийн өндөр буюу 71,9 хувьтай байсан бол “Жонон даатгал” ХХК 0,0 хувьтай байсан байна (Хүснэгт-9).

Хүснэгт - 9

Даатгалын хохирол нөхөлтийн түвшин

№	Даатгалын компаниудын нэрс	Хохирол нөхөлтийн түвшин, хувиар		Өсөлт/бууралт, пунктээр
		2009-1	2010-1	
1	Ард даатгал ХХК	45.5	55.7	10.2
2	Бодь даатгал ХХК	17.4	19.7	2.3
3	Ган зам даатгал ХХК	1.7	4.5	2.8
4	Гранд ко даатгал ХХК	-	0.0	-
5	Жонон даатгал ХХК	0	0.0	0.0
6	Миг даатгал ХХК	30.3	45.8	15.5
7	Монгол даатгал ХХК	32.7	48.9	16.2
8	Монгол траст холдинг даатгал ХХК	0.4	0.0	-0.4
9	Мөнх даатгал ХХК	29.8	15.4	-14.4
10	Номин даатгал ХХК	49.5	48.1	-1.4
11	Прайм женерал даатгал ХХК	20.7	12.5	-8.2
12	Практикал даатгал ХХК	5.2	29.4	24.2
13	Соёмбо инк даатгал ХХК	-	2.6	-
14	Түшиг даатгал ХХК	47.1	63.7	16.6
15	УБ даатгал ХХК	16.1	71.9	55.8
16	Улаанбаатар хотын даатгал ХХК	6.1	32.5	26.4
17	Нийслэл даатгал ХХК	17.3	-	-
18	Юу ай си даатгал ХХК	-	0.0	-
19	Нэйшнл лайф даатгал	0.0	0.0	-
	Дүн	28.6	33.1	4.5

Даатгалын компаниудаас 2010 оны 1 дүгээр улиралд даатгуулагчдад олгосон даатгалын хохирол нөхөлтийн түвшинг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад “Ард даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Ган зам даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Түшиг даатгал” ХХК, “УБ даатгал” ХХК, “Улаанбаатар хотын даатгал” ХХК-иудын хохирол нөхөлтийн түвшин өсч, харин бусад даатгалын компаниудынх өмнөх үеийнхээсээ буурсан дүнтэй гарсан байна.

VI. ДАВХАР ДААТГАЛ

2010 оны 1 дүгээр улиралд ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй 6 компани гадаадын давхар даатгалын компаниудад их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж 1,124.1 сая төгрөгийн хураамж төлсөн нь өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 323.8 сая төгрөгөөр буюу 1,4 дахин өссөн дүнтэй гарлаа (Хүснэгт-10).

Хүснэгт-10

Давхар даатгалын хураамж

(сая төг)

№	Үзүүлэлт	2009-I		2010-I		Өсөлт/бууралт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Ард даатгал ХХК	50	6.2	25.7	2.3	-24.3	51.4
2	Бодь даатгал ХХК	91.4	11.4	412.8	36.7	321.4	4.5 дахин
3	Миг даатгал ХХК	251	31.4	41.0	3.6	-210.0	16.3
4	Монгол даатгал ХХК	260.9	32.6	191.3	17.0	-69.6	73.3
5	Номин даатгал ХХК	3.7	0.5	4.7	0.4	1.0	1.3 дахин
6	Прайм женерал даатгал ХХК	143.3	17.9	434.6	38.7	291.3	3 дахин
	Дүн	800.3	100	1124.1	100.0	323.8	1.4 дахин

VII. ДҮГНЭЛТ

2010 оны 1 дүгээр улиралд даатгалын нийт хураамжийн орлого 2009 оны 1 дүгээр улирлынхаас 28,5 хувиар өссөн дүнтэй гарсан нь даатгалын салбарын хувьд эерэг сайн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтийн дийлэнх нь өмнөх оны 1 дүгээр улиралд бүрэн төлөгдөж байсан давхар даатгалын хураамжийн орлого 2010 онд улирлаар буюу жилийн туршид жигд хуваарилагдан орж ирэхээр болсонтой холбоотой хэдий боловч бусад хүчин зүйл, тухайлбал дэлхийн санхүү, эдийн засгийн байдалд хямралаас гарах нааштай хандлага ажиглагдаж эхэлсэн зэрэг нь манай орны дотоодын санхүүгийн зах зээлд зарим эерэг нөлөөлөл авчирсантай холбоотой гэж дүгнэж болохоор байна. Тухайлбал даатгуулагч иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд өөрсдийн эрсдэлийг удирдаж буруулахын тулд даатгалд даатгуулах сонирхол нь нэмэгдсэн, даатгалын ач холбогдлыг илүүтэй сайн ойлгодог болсонтой холбоотой байна.

Даатгалын хэмжээ нэмэгдэхийн хирээр даатгалын компаниуд өөрсдийн хүлээж болзошгүй даатгалын томоохон эрсдэлийн хариуцлагыг гадны давхар даатгагчдад шилжүүлэн даатгуулж, давхар даатгалд төлсөн хураамж 1,4 дахин өсөн нэмэгдлээ.

Дотоодын даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлдэг даатгалын мэргэжлийн оролцогч нарын тоо нэмэгдэж байгаа нь даатгалын зах зээл өргөжин тэлж байгааг харуулж байна.

ДААТГАЛЫН ГАЗАР